



НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 821

Улаанбаатар хот

「Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын
санхүүжилтийн журам шинэчлэн батлах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 11 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1, 17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталж, 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д ДААЛГАХ нь:

2.1. Нийтийн тээврийн хэрэгслээр иргэд бэлэн мөнгөөр зорчих нөхцөлийг бүрдүүлэн, үйлчилгээний орлого төвлөрүүлэлтийг сайжруулах зорилгоор нийтийн тээврийн үйлчилгээнд бэлэн мөнгөөр зорчих, төлбөр хураахтай холбогдсон харилцааг зохицуулан журам баталж, мөрдүүлэх;

2.2. Нийтийн тээврийн хэрэгслээр "Цахим төлбөрийн карт"-аар бус бэлэн мөнгө төлж зорчсон тохиолдолд үйлчилгээний хөлсийг цахим төлбөрөөс илүү байхаар холбогдох гэрээнд өөрчлөлт оруулах талаар судалж танилцуулах;

2.3. "Цахим төлбөрийн карт"-аар үйлчлүүлсэн зорчигч нийтийн тээврийн нэг чиглэлийн тээврийн хэрэгслээс өөр чиглэлийн тээврийн хэрэгсэлд зорчихдоо 30 минутын дотор дамжин суулт хийхэд ижил болон бага төлбөрийн тарифтай чиглэлд 1 удаа үнэ төлбөргүй, илүү төлбөрийн тарифтай чиглэлд зорчиход зөрүүг нэмж төлөхөөр зохицуулах;


3. Тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 23/14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Ж. БАТБАЯСГАЛАН

111-199269

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2022 оны 09 дүгээр сарын 07-ны
өдрийн 82 дугаар тогтоолын хавсралт



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын хоорондын төлбөр тооцоог түргэн шуурхай явуулах, үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, хяналт тавих, нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүг нийслэлийн төсөвт тусгах, нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.2.1. "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж" гэж нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэж байгаа тээвэрлэгч этгээдийг;

1.2.2. "Нийтийн тээврийн үйлчилгээний орлого" гэж төлбөрийн бүхий л хэлбэрээр төлсөн хөлсийг;

1.2.3. Нийтийн тээврийн үйлчилгээний "Бүртгэл, мэдээлэл, төлбөрийн систем" (БМТС) гэж нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийг бүртгэл мэдээллийн байршил тогтоогч GPS төхөөрөмж ашиглан өдөр тутам бүртгэн ажлын даалгавар, түүний гүйцэтгэл, зөрчлийн мэдээ, зорчигч урсгал, орлого төвлөрүүлэлт, хуваарилалт гэх мэт холбогдох мэдээ, тайлан гаргах нэгдсэн системийг;

1.2.4. "Машин цагийн зардал" гэж нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа автобус, троллейбус нэг цаг ажиллахад гарах зардлыг;

1.2.5. "Машин цагийн гүйцэтгэл" гэж нийтийн тээврийн удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээс Нийтийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын баталсан ажлын даалгаврын дагуу гарсан өдөр, сар, жилээр нэгтгэсэн нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн ажилласан цаг, рейсийг;

1.2.6. "Нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүү" гэж машин цагийн зардлаас нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг хассан дүнг;

1.2.7. "Төсөл хэрэгжүүлэгч" гэж нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэл, мэдээлэл, төлбөрийн ухаалаг шийдлийг нэвтрүүлэх төсөл хэрэгжүүлж буй байгууллагыг;

1.2.8. "Төлбөрийн бүхий л хэлбэрээр төлсөн хөлс" гэж нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн гүйлгээг гүйцэтгэж буй зайнаас уншигдах технологид суурилагдсан төхөөрөмжөөр бүх төрлийн цахим хэлбэрээр болон бэлнээр төлсөн төлбөрийг;

1.2.9. "Карт цэнэглэлтийн дүн" гэж зорчигч карт цэнэглэх бүх төрлийн арга хэлбэрээр цахим төлбөрийн картаа цэнэглэсэн мөнгөн дүнг.

Хоёр. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлэх, хуваарилах

2.1. Нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, нэмэгдүүлэх үйл ажиллагааг нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төсөл хэрэгжүүлэгч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран зохион байгуулна.

2.2. Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсөл хэрэгжүүлэгч, нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй холбогдох харилцааг зохицуулсан гэрээ болон тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээг, төсөл хэрэгжүүлэгч нь нийтийн тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй холбогдсон харилцааг зохицуулсан гэрээг тус тус байгуулж, биелэлтийг хангаж ажиллана.

2.3. Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний орлогын төлөвлөгөө гарган энэ журмын 4.6-д заасан байгууллага, албан тушаалтнаар баталгаажуулж, орлого төвлөрүүлэлтийг хариуцан зохион байгуулж ажиллана.

2.4. Төсөл хэрэгжүүлэгч болон нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь нийтийн тээврийн үйлчилгээний тогтоосон орлогын төлөвлөгөөг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

2.5. Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн мэдээг үндэслэн тухайн өдрийн нийтийн тээврийн үйлчилгээний орлогыг хуваарилан ажлын 2 өдөрт багтаан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад шилжүүлэх ажлыг зохион байгуулна.


2.6. Төсөл хэрэгжүүлэгч, нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагууд нь төлбөр тооцооны цахим болон цаасан баримт, бусад холбогдох материалуудыг хууль тогтоомжийн дагуу архивын нэгж болгон хадгална.

Гурав. Төлбөр тооцооны үйл ажиллагаа

3.1. Төсөл хэрэгжүүлэгч нь нийтийн тээврийн үйлчилгээний орлого төвлөрүүлэх, хуваарилах, төлбөр тооцоо гүйцэтгэхэд нийтийн тээврийн бүртгэл, мэдээлэл, төлбөрийн ухаалаг шийдэл бүхий программ хангамж, тоног төхөөрөмжүүдийг ашиглан бодит цагийн горимоор найдвартай, тасралтгүй явуулах үйл ажиллагааг хариуцна.

3.2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь дээрх системийн үйл ажиллагааны найдвартай байдалд холбогдох мэргэжлийн газар, харьяа нэгжүүдээр дамжуулан тогтмол хяналт тавьж ажиллана.

3.3. Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон төсөл хэрэгжүүлэгчээс ирүүлсэн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын өмнөх сарын ажлын гүйцэтгэлийн тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хянан үзэж, нийслэлийн тухайн төсвийн жилийн санхүүжилтийн гэрээний дагуу "нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүг санхүүжүүлэх" зардлаас нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дансаар дамжуулан нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад дараа сарын 12-ны өдрийн дотор санхүүжүүлнэ.



3.4.Төсөл хэрэгжүүлэгч нь нийтийн тээврийн үйлчилгээний мэдээг нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас гаргасан загварын дагуу өдөр бүр танилцуулж, тайланг сар, улирал, жилээр баталгаажуулж хүргүүлнэ.

3.5.Төсөл хэрэгжүүлэгч нь нийтийн тээврийн үйлчилгээний карт цэнэглэлтийн дансны мэдээллийг өдөр сар, жилээр тухай бүр нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад танилцуулна.

3.6.Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний карт цэнэглэлтийн дүнд хяналт тавьж ажиллах бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь картын системийн нэвтрэх эрхийг өгч, системийн шаардлагатай өөрчлөлт хөгжүүлэлтийг хийж, хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

Дөрөв. Нийтийн тээврийн үйлчилгээний зардлыг тооцоолох, нийслэлийн төсөвт тусгах

4.1.Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зардлын зөрүүг тооцохдоо жилийн үйлчилгээний даалгавар цагийг нэг машин цагийн зардлаар үржүүлж, нийтийн тээврийн үйлчилгээний орлогын дүнг хасаж тооцон, төсөвт тусгуулах саналаа хүргүүлнэ.

4.2.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс нь энэ журмын 4.1-д заасан саналыг хянаж, төсөвт тусгуулна.

4.3.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь улирал, жилийн эцэст санхүүгийн байдлын тайлан, тээвэрлэлтийн нэгдсэн тайлан мэдээг, төсөл хэрэгжүүлэгч нь цахим төлбөрийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр төлсөн төлбөрийн мэдээлэл, борлуулалт, ашиглалтын мэдээг тогтоосон загварын дагуу тус тус үнэн зөв гаргаж нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.


4.4.Инфляцын түвшин, шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалан нэг машин цагийн зардалд өөрчлөлт орох тохиолдолд нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь холбогдох судалгаа, тооцооллыг хийж төсөвт тусгуулах саналаа Нийслэлийн Засаг даргаар уламжлуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлнэ.

4.5.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь энэ журмын дагуу хийгдэх бүхий л төлбөр тооцоо, мэдээлэл, судалгаанд хяналт тавьж ажиллана.

4.6.Нийслэлийн тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь орлого төвлөрүүлэлтийн талаарх тайлан, мэдээллийг хагас жил тутамд Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд, улирал тутамд нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчид, сар бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст тус тус танилцуулж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1.Энэ журмын 2.2-т заасан гэрээний биелэлт "хангалтгүй" үнэлгээтэй дүгнэгдсэн эсхүл дүгнэгдээгүй бол тухайн нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагад нийтийн тээврийн үйлчилгээний орлого, зарлагын зөрүү санхүүжилтийг олгохгүй.



5.2.Энэ журмын 2.2-т заасан гэрээний биелэлт “хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн эсхүл дүгнэгдээгүй бол төсөл хэрэгжүүлэгчид олгох ажил үйлчилгээ эрхэлсний шимтгэлийг олгохгүй.

5.3.Төсөл хэрэгжүүлэгч нь нийтийн тээврийн бүртгэл, мэдээлэл, төлбөрийн ухаалаг шийдэл бүхий программ хангамж, тоног төхөөрөмжүүд доголдсон, нийтийн тээврийн үйлчилгээний бодит цагийн горимоор найдвартай, тасралтгүй явуулах үйл ажиллагааг алдагдуулсан. энэ журмын 2.3-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох гэрээний дагуу олгогдох ажил, үйлчилгээ эрхэлсний шимтгэлээс 30 хүртэл хувиар хасаж тооцно.

5.4.Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын “Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх” гэрээний үүргийн биелэлтийг харгалзаж олгогдох санхүүжилтээс 30 хүртэл хувиар хасаж тооцон санхүүжилтийн олгоно.

5.5.Энэхүү журмын 5.1-5.4-т заасан хариуцлагын талаар журмын 2.2-т заасан гэрээнд нарийвчлан тусгасан байна.

